



АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨНӨӨС ӨГӨГДСӨН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН ХЭРЭГЖИЛТ



2024 оны 06 дугаар сарын 24-ний өдөр

ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР



1. Аймгийн баяр наадам, Хангайн бүсийн Илгээлтийн эздийн 50 жилийн ойн арга хэмжээг өндөр түвшинд зохион байгуулахад онцгой анхаарч, бэлтгэл ажлыг сайтар хангаж ажиллах. (засварын ажлуудыг эртнээс хийж эхлэх)

Хугацаа: 07 дугаар сарын 31-ний дотор





Биелэлт: НБХ

Аймгийн баяр наадам, Хангайн бүсийн Илгээлтийн эздийн 50 жилийн ойн арга хэмжээний бэлтгэл ажлын хүрээнд "Эрдэнэт спорт амралтын хүрээлэн"-д засвар үйлчилгээний ажлыг хийж гүйцэтгэхээр шалгарсан "Билэг хайрхан" ХХК-тай гэрээ байгуулан төлөвлөгөөний дагуу ажил хийгдэж байна.

Хэрэгжилт: Хэрэгжиж байна.

НАЙРАМДАА - ДУУЖДА



Биелэлт: ЦШ

Аймгийн баяр наадам, Хангайн бүсийн хурд, Илгээлтийн эздийн 50 жилийн ойн арга хэмжээг зохион байгуулах салбар комиссын бүрэлдэхүүнд ажиллах албан хаагчдыг томилон баяр наадам зохион байгуулахад шаардлагатай төсвийг аймгийн ИТХ-аар батлуулсан. Салбар комиссын бүрэлдэхүүн бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

Хэрэгжилт: Хэрэгжиж байна.



2. А1001, А1002 авто зам дагуух төмөр хашлагуудын эвдэрсэн хэсгийг сэргээн засварлах. (Бургалтайн гүүрний орчим гэх мэт)

Хугацаа: 06 дугаар сарын 30-ны дотор





Биелэлт: ХЗА

А1001, А1002 дугаартай авто зам дагуух хөдөлгөөний аюулгүй байдал, хотын өнгө үзэмжид нөлөөлөх эвдэрсэн төмөр хашлагуудыг хураан авч засварлах ажил 2024 оны 06 дугаар сарын 21-ний өдрөөс эхлээд байна. А1001 авто зам дагуух Бургалтайн гүүрний туузан хашлагыг 2024 оны 07 дугаар сард засварлах ажлыг эхлэхээр төлөвлөн ажиллаж байна.

Хэрэгжилт: Хэрэгжиж байна.



3. А1002 авто замд 4 эгнээ замын өргөтгөл хийж байгаа хэсгийн замын ачаалалд зохицуулалт хийж ажиллах. Хаасан үед зорчих хэсгийг тодорхой болгох иргэдэд мэдээллийг хүргэх.

Хугацаа: Тухай бүрд





Биелэлт: ЦГ

Улсын чанартай А1002 дугаартай авто замын өргөтгөл шинэчлэлт хийх ажлын гүйцэтгэгчээр шалгарсан "Шилдэг зам" ХХК-ийн замын инженерт авто зам хаах, ажил эхлэх үед хуваарь гарган зохицуулалт хийх талаар мэдэгдсэн.

Хэрэгжилт: Хэрэгжих шатандаа.





Биелэлт: Баян-Өндөр сумын ЗДТГ

Согоот багийн баруун уулзвараас Их залуу баг хүртэлх А1002 дугаартай авто замын 1.9 километр урттай хэсэгт өргөтгөлийн ажил эхэлж хөрс хуулалтын шатандаа явж байгаа мэдээллийг Баян-Өндөр сумын ЗДТГ-ын цахим хуудсанд байршуулж 6782 иргэнд хүргээд байна.

Хэрэгжилт: Хэрэгжиж байна.

Баян-Өндөр Сум ЗДТГ

Орхон аймгийн Баян-Өндөр сумын ЗДТГ-аас хийж хэрэгжүүлж буй ажлуудыг иргэн танд мэдээлнэ.

Хуудас · Орон нутгийн үйлчилгээ

Орхон аймаг, Баян-Өндөр сум, Оюут баг, Захиргааны 2-р байр, Erdenet, Mongolia

7035 3611

buzdtg@gmail.com

bayanundur.mn

Хараахан үнэлээгүй (0 шүүмж)

Зураг Бүх зургийг харах

ХАРИЦЛЫН ӨВЧНИЙ ТАЛААРХ
ХАРШЛААС СЭРГИЙ

Согоот багийн баруун уулзвараас Их залуу баг хүртэлх А1002 дугаартай авто замд байрлах нийт 1,9 километр урттай авто замын өргөтгөлийн ажил эхэлж хөрс хуулалтын шатандаа явж байна.



4. Баян-Өндөр сумын хэмжээнд шарилж устгал явагдаж байгаа холбоотой хог ачилтын асуудалд онцгой анхаарах. Холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах.

Хугацаа: Тухай бүрд





Биелэлт: ХТГ

Хот тохижуулах газар нь орон сууцны хорооллын шарилж, зэрлэг ургамлыг ачиж тээвэрлэх бөгөөд 2024 оны 06 дугаар сарын 19-ний өдрөөс Хүрэнбулаг, Уурхайчин багуудын зэрлэг ургамлыг цэвэрлэх ажил хийгдэж эхлээд байна.

Хэрэгжилт: Хэрэгжиж байна.

НАЙРАМДАА - ДРЧУЖДА



Биелэлт: Баян-Өндөр сумын ЗДТГ

Цаг агаарын нөхцөл байдлаас шалтгаалан шарилж устгах бодис цацах ажил тодорхойгүй хугацаагаар хойшлогдоод байна.





АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА

2024 он

НАЙРАМДАЛ - ДРЧУЖДА

